



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт



**ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ
БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХУУЛЬ,
ЖУРМЫН ДАГУУ ХУГАЦААНДАА
ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.**

Өлгий

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган Аудитын менежер Х.Женисбек Ахлах аудитор К.Риза М.Айнур Аудитор Д.Назгүл Б.Үүрийнтуяа 2017 оны 12 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 94156768, 94159291 дугаарын утсаар харилцана уу ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр 1 дүгээр давхар 105, 106, 108 тоот өрөө	Товчилсон үгийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4-5 Бүлэг 1 Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулаагүй байна. 6-11 1.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах төлөвлөгөө байхгүй байна. 6-7 1.2 Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, зорилго зорилтын уялдааг тодорхойлж бодлогын хувилбаруудыг боловсруулах ажил хийгдээгүй байна. 7 1.3 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгдээгүй, хууль журмын дагуу боловсруулж олон нийтээр хэлэлцүүлүүлээгүй байна. 7-8 1.4 Зарим сумуудын хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгаагүй байна. 8-9 1.5 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг холбогдох байгууллагад хүргүүлж зөвшөөрөл авчээ. 10 1.6 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, төслийг нэгтгэн боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан байна. 10-11 Бүлэг 2 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журмын дагуу тайлагнаагүй байна. 12-13 2.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журамд заасан хугацаанд тайлагнаагүй байна. 12 2.2 Сумуудын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хууль журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй, хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулаагүй байна. 13 2.3 Аймаг, сумуудын ИТХурал нь хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна. 13 Бүлэг 3 Хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлах ажлыг зохих түвшинд хийж ирсэн байна. 14-15 3.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчилах ажлыг зохих түвшинд хийж ирсэн байна. 14 3.2.Ногооннуур сумын Засаг дарга Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулинд заасан Засаг даргын үүргээ хэрэгжүүлээгүй байна 14-15 Дүгнэлт..... Зөвлөмж: Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал Саналд өгсөн тайлбар
--	--

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхий аудиторт Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт”-нд нийцлийн аудит хийж хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх үүрэг хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт гарган, аудитын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах санал зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрхи зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийлээ.Үүнд:

- Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт- шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа эсэх

Хамарсан хүрээ

Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг мөрдөгдөж эхэлсэн 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс хойших хугацаанд боловсруулан баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд аймаг, сумын ИТХурал, Засаг дарга түүний Тамгын газрын үйл ажиллагааг хамрууллаа.

Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, харилцан ярилцлагад тулгуурлан хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ. /Хавсралт №1/

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглана.

Асуудлын талаар товч мэдээлэл

Баян-Өлгий аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дунд хугацааны 25 бодлогын баримт бичиг, богино хугацааны 10 бодлогын баримт бичиг байна.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг ахлах аудитор К.Риза ахалж, ахлах аудитор М.Айнур, аудитор Д.Назгүл, Б.Үүрийнтуяа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг төлөвлөгөө, хөтөлбөр, ажлын хуваарийн дагуу хийж, аудитын тайланг бэлтгэв. Аудитын тайлангийн хавсралт судалгаа, мэдээнүүдийг тайланд хавсаргав.

Бүлэг 1

*Хөгжлийн бодлогын зарим баримт бичгийг хууль, журамд
нийцүүлэн төлөвлөж, боловсруулаагүй байна.*

Оршил

Баян-Өлгий аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дунд хугацааны 25 бодлогын баримт бичиг байна. Үүний 10 нь 8-10 жилийн хугацаанд хэрэгжих, 15 нь 4 жилийн хугацаанд хэрэгжих, богино хугацааны 10 бодлогын баримт бичиг байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдаж гарахаас өмнө дараах дунд хугацааны 10 бодлогын баримт бичиг батлагджээ.

Баян-Өлгий аймгийн 2010-2021 оны хөгжлийн хөтөлбөрийг 2010 онд боловсруулан баталсан байна.

Үүнээс гадна 2013-2014 онд 9 сум сумын хөгжлийн дунд хугацааны бодлогоо тодорхойлж, Сагсай сум 2013-2021 онд хэрэгжих 8 жилийн хугацааны “Сумын хөгжлийн хөтөлбөр”-ийг 2013 онд, Алтай, Алтанцөгц, Бугат, Булган, Буянт, Улаанхус, Толбо, Цэнгэл сум “Сумын хөгжлийн хөтөлбөр”, “Сумын мастер төлөвлөгөө”, “Сумын хэтийн төлөвлөгөө” нэртэйгээр 2014-2024 онд хэрэгжих 10 жилийн хугацааны бодлогын баримт бичгийг 2014 онд батлан гаргасан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдсанаас хойш дараах 25 бодлогын баримт бичиг батлагджээ.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”, “Сав, баглаа, боодол дэд хөтөлбөр”, “Стандарттай Баян-Өлгий дэд хөтөлбөр”, Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл зэрэг 5 бодлогын баримт бичгийг аймгийн ИТХ-аар хэлэлцэж, баталжээ.

Мөн Ногооннуур сумаас бусад 12 сум, 1 тосгоны Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 7 сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл зэрэг 20 бодлогын баримт бичгийг сумдын ИТХ-аар хэлэлцэж, баталсан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 2016 оны 11 дүгээр сард батлагдаж, хуулинд заасан бодлогын баримт бичгийн төсөл боловсруулахтай холбоотой Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ыг, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус батлан гаргажээ.

1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөсөн эсэх талаар.

Хөгжлийн бодлогын зарим баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулаагүй байна.

1.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах төлөвлөгөө боловсруулан ажилласан эсэх талаар.

Дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах төлөвлөгөө хийгдээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 17-д “Энэ журмын 12,13-т заасан Ажлын хэсэг нь төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна” гэж заасан бөгөөд аймгийн түвшинд журмын 13-т заасан аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулагдахаар журамлагдсан байна.

Дээрхи журамд зааснаар хууль батлагдсаны дараа боловсруулагдсан бодлогын баримт бичгүүдээс аймгийн ИТХ-аар батлуулан аймгийн хэмжээнд мөрдөгдөж байгаа 3 дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг нь төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байхаар журмын заалттай боловч “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”, “Сав, баглаа, боодол дэд хөтөлбөр”, “Стандарттай Баян-Өлгий хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаагүй, төсөл боловсруулах төлөвлөгөө хийгдээгүй байна.

1.2.Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийн, зорилго зорилтын уялдааг тодорхойлж бодлогын хувилбаруудыг боловсруулсан эсэх талаар.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийгдээгүй, бодлогын хувилбаруудыг боловсруулаагүй байна.

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”, “Сав, баглаа, боодол дэд хөтөлбөр”, “Стандарттай Баян-Өлгий хөтөлбөр” боловсруулахад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 20-23-д заасны дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, дүн шинжилгээнд үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын уялдааг тодорхойлон, бодлогын хувилбаруудыг боловсруулах ажил хийгдээгүй байна.

Харин аймгийн ХХААГазар, СХЗТөвийн мэргэжилтнүүд ажлын чиг үүргийн дагуу дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан аймгийн ИТХ-д оруулан батлуулжээ.

1.3.Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийн, хууль журамд заасан /бүтэц, агуулга, хүснэгт/ хүрээнд боловсруулж, олон нийтээр хэлэлцүүлсэн эсэх талаар.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгдээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 24-26-д заасны дагуу төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага нь нөлөөллийн урьдчилсан үнэлгээг судалгаа, үнэлгээ албан ёсны тоон мэдээлэлд үндэслэн, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлтийг төсөлд тусгасан байхаар заасан боловч нийтлэг журмын 13-д заасан дээрхи 3 хөтөлбөрийн төсөлд нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгдээгүй байна.

1.4.Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг бодитой тусгасан эсэх талаар.

Зарим сумуудын хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгаагүй байна.

Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсээс боловсруулан аймгийн ИТХ-ын 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 11 тоот тогтоолоор батлагдсан “Стандарттай Баян-Өлгий” хөтөлбөр, аймгийн ХХААГазраас боловсруулан аймгийн ИТХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 61, 62 дугаар тогтоолуудаар батлагдсан “Сав баглаа боодол”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрүүд нь “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 52-т заасан нөхцөл байдал, бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх үе шат, бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт, шаардагдах хөрөнгийн хэмжээ зэрэг ерөнхий бүтэц, агуулгатай байна.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 61-д заасны дагуу

- ✓ Эдийн засгийн хөгжлийн бодлого,
- ✓ Дэд бүтцийн салбарын бодлого,
- ✓ Нийгмийн хөгжлийн бодлого,
- ✓ Байгаль орчин ногоон хөгжлийн бодлого,
- ✓ Засаглалын бодлого зэрэг 5 бодлогын зорилго, зорилтуудыг тусгасан бүтэцтэй ба ерөнхий мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээ хийх төлөвлөгөөг хавсаргасан байна.

Сумууд журамд заасан бүтцийн дагуу үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулсан боловч Ерөнхий мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээ хийх төлөвлөгөөг хавсаргаагүй байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжих хугацаа, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хөрөнгийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ, хэрэгжүүлэгч байгууллагын нэрээр нийтлэг журмын 62-д заасны дагуу энэхүү журмын 8 дугаар хавсралт маягтаар гаргасан байна.

Алтай, Алтанцөгц, Баяннуур, Булган, Бугат, Буянт, Дэлүүн, Толбо, Улаанхус, Сагсай, Цэнгэл, Өлгий сумдын Засаг дарга болон Цагааннуур тосгоны захирагчаас 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан 2016 оны 11, 12 дугаар саруудад батлуулсан ба Ногооннуур сум сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2017 оны үндсэн чиглэлээ боловсруулан батлуулаагүй байна.

Сагсай, Булган, Бугат, Толбо, Цэнгэл сумдаас бусад сум хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг журамд заасан хавсралт маягтын дагуу гаргаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх 487 арга хэмжээний төлөвлөгөөг авч хэлэлцээд ИТХ-ын 10 дугаар тогтоолоор баталжээ.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 бүлэг, 23 дэд бүлэг, 265 зорилт тусгагдсан байна.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго нь 2010 онд батлагдсан “Баян-Өлгий аймгийн 2010-2021 оны хөгжлийн хөтөлбөр” буюу аймгийн хэтийн зорилттой уялдаж байгаа ба Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 67 зорилтыг хэрэгжүүлэхээр тусган 213 арга хэмжээг төлөвлөж оруулан нийтлэг журмын 55.6-д заасан зорилго, зорилтын уялдааг хангасан байна.

Дээрхи сумдын Засаг дарга нарын боловсруулсан 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийг аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 13 тоот тогтоолоор батлуулсан байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор ИТХ-д өргөн мэдүүлж, тухайн шатны ИТХ батална” гэсэн хугацааг мөрдөөгүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн аймгийн 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулан 188 арга хэмжээг шаардагдах хөрөнгийн дүнтэй төлөвлөсөн байна.

Булган, Буянт, Толбо, Сагсай, Улаанхус, Цэнгэл, Өлгий сум сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн сумын 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулан баталсан боловч Буянт, Булган, Улаанхус, Өлгий, Сагсай, Толбо сумууд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16.2-т заасан хугацаанд батлуулаагүй байна.

Бугат, Булган, Толбо, Сагсай, Цэнгэл сумаас бусад сум Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулаагүй, Алтай, Баяннуур, Бугат, Дэлүүн, Ногооннуур сум 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулаагүй зэргээр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн тооцоо судалгаатай бодлогын баримт бичгүүдийг боловсруулан батлаагүй, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.5.Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг журамд заасны дагуу зохих байгууллагад хүргүүлж зөвшөөрөл авч, эрх бүхий этгээдээр батлуулсан эсэх талаар.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг холбогдох байгууллагад хүргүүлж зөвшөөрөл авчээ.

Аймгийн ХХААГазраас боловсруулсан “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”, “Сав, баглаа, боодол дэд хөтөлбөр”, Стандарт хэмжил зүйн хэлтсээс боловсруулсан “Стандарттай Баян-Өлгий хөтөлбөр”-ийн төслийг холбогдох тооцоо судалгааны хамт аймгийн ИТХ-ын ажлын албанд ирүүлсэнийг хурлын байгууллагаас судалж үзээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж баталсан байна.

1.6.Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, төслийг нэгтгэн боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлсэн эсэх талаар.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, төслийг нэгтгэн боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/506 дугаар захирамжийн дагуу Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан ЗДТГазрын хэлтсийн дарга, бодлого хариуцсан мэргэжилтнүүд, Засаг даргын харьяа газар, албадын дарга, иргэдийн төлөөлөгчдийн төлөөлөл, ахмадын төлөөллийг оролцуулан 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Уг ажлын хэсэг нь Эдийн засгийн хөгжлийн бодлого, Дэд бүтцийн хөгжлийн бодлого, Нийгмийн хөгжлийн бодлого, Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, Засаглалын бодлого зэрэг 5 бодлогыг тодорхойлох салбар комисс байгуулан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Хөгжлийн хөтөлбөр, сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийг судлах, салбарын байгууллагууд болон бүх сум, байгууллагуудаас санал авч нэгтгэх ажлуудыг хийсэн байна.

Үүний үндсэн дээр Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг тодорхойлж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар зорилт, арга хэмжээг заалт бүрээр хэлэлцүүлэн үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулжээ.

Боловсруулсан төслийг аймгийн Иргэний танхимын цахим хуудсаар ард иргэдэд мэдээлэн, санал авах ажлыг зохион байгуулж, санал авч тусган, төслийг эцсийн байдлаар ажлын хэсгээр хэлэлцэж, аймгийн ЗДТГазрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэстэй хамтран хөтөлбөрийг боловсруулсан байна.

Сагсай сум Засаг даргын захирамжаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах сумын ажлын хэсгийг байгуулан ажилуулсан байна. Бусад сумдын хувьд сумдын ЗДТГазраас аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэл болгон сумын төсөвт байгууллагууд, иргэдийн

төлөөллөөс авсан саналыг нэгтгэн тусгах замаар сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулжээ.

Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, саналыг нэгтгэхдээ нийтлэг журмын 3-р хавсралтаар заасан маягтаар гаргаагүй байна.

Боловсруулан гаргасан бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилтууд Төсвийн тухай хуулинд заасан тухайн шатны Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд хэр нийцэж байгааг шалгаж үзэхэд Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1 дэхь зорилтын 1.1.1, 1.1.3, 1.1.4, 5 дахь зорилтын 5.3.7 дахь дэд зорилт нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхэд үл хамаарах арга хэмжээнүүд байна.

Сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт сумын Засаг даргын бүрэн эрхэд хамааралгүй, Төсвийн тухай хуулийн 58.4-д заасан чиг үүрэгт нийцээгүй арга хэмжээнүүд төлөвлөгдөөгүй байна.

Бүлэг 2

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль
журмын дагуу хугацаандаа тайлагнаагүй байна.

2.Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх талаар.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журмын дагуу хугацаандаа тайлагнаагүй байна.

2.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журамд заасан хугацаанд тайлагнасан эсэх талаар.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журамд заасан хугацаанд тайлагнаж, ИТХ-д оруулж хэлэлцүүлж, дүгнүүлээгүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ”, 16.2-т “нутгийн захиргааны байгууллага эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална”,

16 дугаар зүйлийн 16.3-д “Иргэдийн төлөөлөгчдийн хурал эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэн дүгнэнэ” гэж заасны дагуу аймаг, сумын Засаг дарга нар 2016, 2017 онд хөтөлбөрийн болон үндсэн чиглэлийн хэрэгжилтийг ИТХ-аар хэлэлцүүлэн дүгнүүлсэн эсэхийг шалгаж үзэхэд 2016 онд Цэнгэл сумын ИТХ-аас Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын 2016 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэлэлцүүлсэн ба бусад сум дээрхи бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг гаргаж ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна.

Аймгийн ЗДТГазрын Хяналт шинжилгээ, үнэлгээний тасгаас Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Аймгийн 2016 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тооцож гаргасан боловч Аймгийн ИТХурлаар хэлэлцүүлж, дүгнүүлээгүй байна.

2017 оны хувьд Аймгийн ЗДТГазрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Аймгийн 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тооцож гаргасан боловч Аймгийн ИТХурлаар хэлэлцүүлж, дүгнүүлээгүй байна.

Сумууд Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг дүгнэж сумын ИТХ-аар хэлэлцүүлж, дүгнүүлээгүй байна.

2.2.Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хууль журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулж байгаа эсэх талаар.

Сумуудын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хууль журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй, хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан аргачлалын дагуу Аймгийн ЗДТГазрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2016 оны 6 дугаар сарын 20-ны байдлаар Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2016 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг гаргасан байна.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэнд үнэлгээ хийж, дүгнэлтийг аймгийн ИТХ-д 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 3-02/2155 тоот албан бичгээр хүргүүлсэн ба 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг гарган үнэлгээ хийж бэлэн болгосон байна.

Сагсай, Буянт, Цэнгэл сум сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэлийн биелэлтийг, Цагааннуур тосгоны захирагчийн 2016-2019 оны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг 2016 оны байдлаар гаргасан байна. Харин бусад сумууд хөтөлбөр, үндсэн чиглэлийн биелэлтийг гаргаагүй байна

2.3.Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх талаар

Аймаг, сумын ИТХурал хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Тухайн шатны ИТХурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэнэ" гэж заасны дагуу аймаг, сумын ИТХ-ын байгууллагаас шат шатны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэнд хяналт тавих эрх үүрэгтэй байна.

Аймгийн ИТХ-аас аймгийн Засаг даргын 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2016, 2017 оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцэж, дүгнээгүй байна.

Цэнгэл сумын ИТХ-аас бусад сумын ИТХурал сумын Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сумын 2016, 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хэлэлцэж, дүгнээгүй байна.

Бүлэг 3

Хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлах ажлыг
зохих түвшинд хийж ирсэн байна.

3.Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэх талаар.

3.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэх талаар.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлах ажлыг зохих түвшинд хийж ирсэн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2-д заасны дагуу аймаг, сумын ЗДТГазраас батлагдсан бодлогын баримт бичгүүдийг олон нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх, сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, 2017 оны үндсэн чиглэлийг “Bayan-Ulgii.gov.mn” сайтад байршуулж, орон нутгийн “Монгол Заман” сонин, Орон нутгийн олон нийтийн радио, телевизээр сурталчилж, Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эмхтгэл гаргаж, мэдээллийн самбарт тавьж сурталчилсан байна.

Сумын ЗДТГазрууд Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, 2017 оны үндсэн чиглэлийг тухайн сумдын веб сайтад байршуулж, иргэдийн нийтийн хуралд танилцуулж, мэдээллийн самбарт тавьж сурталчилжээ. Алтанцөгц, Баяннуур, Булган, Улаанхус сум веб сайтад мэдээлэл байршуулаагүй байна.

3.2.Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга түүний агентлаг, байгууллага, ЗДТГ хууль журамд заасан үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар

Ногооннуур сумын Засаг дарга Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулинд заасан Засаг даргын үүргээ хэрэгжүүлээгүй байна

Ногооннуур сумын Засаг дарга сумын хөгжлийн бодлогоо тодорхойлж, үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийг боловсруулан батлуулаагүйгээр Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2-д заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Мөн сумын ИТХурал нь ХБТ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ” 16.3-т “Иргэдийн төлөөлөгчдийн хурал эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэн дүгнэнэ” гэж заасан эрх үүргийн хүрээнд сумын Засаг даргын үйл ажиллагаанд тавих хяналтаа хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Алтай, Алтанцөгц, Баяннуур, Дэлүүн, Ногооннуур сумын 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж батлуулаагүй байгаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 16 дугаар зүйлийн 16.2-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Бүх шатны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн хэрэгжилтийг дүгнэх ажлыг ИТХурлын байгууллага хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулинд заасан бодлогын баримт бичгүүдээс Ногооннуур сум сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг, Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Дэлүүн, Ногооннуур сумын 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулаагүй зэргээр дээрхи сумдын Засаг дарга нар ХБТ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 16 дугаар зүйлийн 16.2-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Бүх шатны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийг хэрэгжилтийг дүгнэх ажилд ИТХурлын байгууллагаас тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Аудитын дүнгээр Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулинд заасан үүргээ хэрэгжүүлээгүй байгаа Ногооннуур сумын Засаг дарга К.Хуанышт Төрийн аудитын тухай хуулинд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасан эрх хэмжээний хүрээнд сахилгын шийтгэл ногдуулахаар албан шаардлага өгөгдөв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах төлөвлөгөө хийгдээгүй байна.
2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийгдээгүй, бодлогын хувилбаруудыг боловсруулаагүй байна.
3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгдээгүй байна.
4. Зарим сумын хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгаагүй байна.
5. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг холбогдох байгууллагад хүргүүлж зөвшөөрөл авчээ.
6. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, төслийг нэгтгэн боловсруулах чиг, үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.
7. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журамд заасан хугацаанд тайлагнаж, ИТХ-д оруулж хэлэлцүүлж, дүгнүүлээгүй байна.
8. Сумуудын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хууль журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй, хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулаагүй байна.
9. Аймаг, сумуудын ИТХурал нь хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.
10. Хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлах ажлыг зохих түвшинд хийж ирсэн байна.
11. Ногооннуур сумын Засаг дарга Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2-д заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХурлын дарга Д.Бауыржан танаа:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16.2-т заасан хугацаанд хэлэлцэж, дүгнэж байх.
2. Сумдын ИТХ-д тухайн шатны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хуулинд заасан хугацаанд нь хэлэлцэж, дүгнэх талаар чиглэл, хяналт тавьж ажиллах.

Аймгийн Засаг дарга А.Гылымхан танаа:

1. “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам” -ын 12,13-т заасан бодлогын баримт бичгийг боловсруулахдаа ажлын хэсгийг байгуулж, журмын 18-д заасны дагуу боловсруулах.
2. Аймаг, сумын Засаг дарга нар бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжилтийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан хугацаанд тайлагнаж байх.
3. Сумдын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулахад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5-д заасан хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчмыг мөрдөж ажиллах.

Ногооннуур сумын ИТХ-ын дарга Д.Талгатбект:

1. Танай Сумын Засаг дарга Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,15.2, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2-т заасан Засаг даргын чиг үүргийг хэрэгжүүлээгүй байгаад дүгнэлт хийж, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.3, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасан ИТХ-ын бүрэн эрхийн хүрээнд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

83129 Өлгий, Өлгий сум, Баян-Өлгий аймаг
Утас: 7042-2455, Факс: 70423728

БАЯН-ӨЛГИЙН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА М.ХУАНГАН ТАНАА

2017.12.19 № 1-01/415
танай _____ -ны № _____ -г

Санал хүргүүлэх тухай

Тус аймаг дахь аудитын газраас 2017 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 275 албан тоотоор ирүүлсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийсэн тайлантай танилцаж дараах саналуудыг хүргүүлж байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих ажил хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу хэрэгжихгүй байгаатай санал нэг байна. Цаашид хуулийг хэрэгжүүлэхэд дараах ажлуудыг анхаарч ажиллах болно.

ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн аймгийн хэмжээний бодлогын баримт бичгүүдийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, хэрэгжилтийг хангах журмыг "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын хүрээнд шинээр боловсруулан батлуулах.

- Тэргүүлэгчдийн хуралдаанаар Төлөвлөлт, хяналтын хороог оролцогч талуудын төлөөллийг оролцуулан шинээр байгуулан, ажиллах журмыг батлах.


- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14, 1 дэх заалтын дагуу 2018 онд аймгийн стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулах чиглэл өгч ажиллах.

- Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлтүүдийг орон нутгийн онцлогт тохируулан боловсруулан батлах.

- Бүх шатны ИТХ-ын байгууллагаас Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтийг үнэлж хянах үүрэг бүхий ажлын хэсгийг ИТХ-ын дэргэд оролцогч талуудын төлөөллийг оролцуулан байгуулж, үнэлгээ хийсэн тухай сонгол мэдээллийг хагас бүтэн жилээр хуралдаанаар хэлэлцэж байх.

- Сумуудын ИТХ-д Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтын дагуу аймгийн ИТХ-ын ажлын албанаас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах.

ДАРГА



Д. БАУЫРЖАН

//by documents/blankA4/book.doc

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

К.РИЗА

АХЛАХ АУДИТОР

М.АЙНУР

АУДИТОР

Д.НАЗГҮЛ

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА